



2021

CAPITAL EXCHANGE OF MONGOLIA

WHITE PAPER

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ
ТӨВЛӨРСӨН, ДИЖИТАЛ
ХӨРӨНГИЙН БИРЖ

VERSION 2

Алсын хараа

Хэрэглэгчдэдээ олон улсын болон дотоодын хөрөнгийн зах зээлд мэргэжлийн түвшинд нэг дор арилжаа хийх боломжийг олгож, Эх орондоо валютын болон оюун санааны бодит хувь нэмэр оруулсан бирж байна.



Зорилго

Дэлхийн хөрөнгийн зах зээлийн бүхий л боломж, стандартуудыг бүрэн хангасан, төвлөрсөн дижитал хөрөнгийн биржийг Монголдоо нэвтрүүлж, олон улсын хөрөнгийн биржүүдэд, үндэсний цөм баялаг болсон уул уурхай, хөдөө аж ахуй болон түүхий эд материалуудыг гаргах замаар гаднын хөрөнгө оруулагчдыг татах гүүр нь байна.

DATA LAND

TECH



Даталанд ХХК-ийн хамт олон нь өөрсдийн мэдээллийн технологийн салбарт хуримтлуулсан туршлага, ур чадварууд дээрээ суурилан 2019 онд үүсгэн байгуулагдаж, программ хангамж, системийн интеграцлал болон техникийн шийдлийн чиглэлээр Монгол улсын мэдээллийн технологийн зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Үүсгэн байгуулагдсанаасаа хойш богино хугацаанд манай хамт олон нь иргэдэд зориулсан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг хуулийн технологид суурилсан ухаалаг платформоор дамжуулан авах боломжтой “iLaw-таны цахим хуульч” үйлчилгээний хөгжүүлэлт, шийдлийг амжилттай гүйцэтгэж олон нийтэд хүргээд байна.

Мөн бид улсын төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг сайжруулах, нэгдсэн системд оруулан удирдах боломжтой болгох open-gov.mn төслийн программын хөгжүүлэлтийг гүйцэтгэгч байгууллагаар шалгаран ажиллаж байна.

EXPERIENCE

 АЖЛЫН ТУРШЛАГА



НӨАТ-ЫН БУЦААН ОЛГОЛТ БОЛОН И-БАРИМТ

Татварын орлогыг нэмэгдүүлэх, татварын хяналтыг сайжруулах, тэгш шударга байдлыг хангах зорилгоор 2016 оны 01 сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн “Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем” болон цахим төлбөрийн баримтын И-баримт-ын системийн архитектур, хөгжүүлэлтүүдийг хариуцан гүйцэтгэж байсан хамт олон. И-баримт нь сая гаруй хэрэглэгчтэй татварын албанаас иргэдтэй харилцах хамгийн том суваг нь болоод байна.



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИН - ТҮЦ МАШИН

Монгол Улсад төрийн үйлчилгээний цахим машины үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд өөрт хамгийн ойр байрлаж буй “ТҮЦ” машинаас төрийн үйлчилгээнүүдийг авах боломжийг бүрдүүлсэн билээ. Энэхүү үйлчилгээний техникийн шийдэл, системийн архитектур, программ хөгжүүлэлтийг гүйцэтгэх төслийн багийн гишүүдээр оролцож байсан туршлагатай.



Монгол улсад криптовалюта, блокчэйн технологи эрчимтэй хөгжиж, уламжлалт санхүү болон хөрөнгийн зах зээлийн салбарт цоо шинэ технологийн дэвшил, боломжийг бий болгож байна. Энэхүү өөрчлөлтийг бий болгоход шинээр үүсэж буй крипто биржүүд нь ихээхэн чухал үүргийг гүйцэтгэж байгаа. Мөн хэрэглэгчид зөвхөн крипто бус, валют арилжаа FOREX болон бусад олон улсын түүхий эд болон металлын биржүүд дээр арилжаа, хөрөнгө оруулалтыг хийж байгаа хэрэглээ, эрэлтийг тус тус үндэлсэн Даталанд ХХК-ийн зүгээс сүүлийн нэг жилийн хугацаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төвлөрсөн биржийн системүүдийг судлан, олон улсын хууль эрх зүй, комплайнсын шаардлагуудыг бүрэн хангахаас гадна, системийн хүчин чадалтай Modulus биржийн системийг Монголд нэвтрүүлэхээр ажиллан бэлэн болгоод байна.

Биржийн үйл ажиллагаа нь олон улсын стандартын дагуу хатуу чанга, хууль эрх зүйн зохицуулалт, журмын хүрээнд явагддаг бөгөөд олон улсын биржүүдтэй холбогдоход тухайн биржийн системийн хүчин чадал, хэрэглэгч, хөрөнгө оруулагчийг урьдчилан таних Know-Your-Customer (KYC) хяналтын системтэй эсэх болон бусад олон улсын комплайнсын шаардлагуудыг хангасан эсэхийг нарийвчлан шалгадаг. Эдгээр техникийн шаардлагуудыг CAPEX биржийн систем нь бүрэн хангаж байна. Биржийн систем нь АНУ-д төвтэй, дэлхийн шилдэг хөрөнгийн биржүүд, үндэстэн дамнасан банк, санхүүгийн корпорацуудын ашигладаг “Modulus” систем дээр суурилсан. Энэхүү систем нь олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын комплайнс стандартуудыг бүрэн хангасан ба мөнгө

угаах, санхүүгийн гэмт хэрэг болон луйврын зориулалттай хуурмаг гүйлгээнүүдээс урьдчилан сэргийлэх хяналтын цогц горимтой.



ОЛОН УЛСАД ҮНЭЛЭГДСЭН “**MODULUS**” БИРЖИЙН СИСТЕМ

CAPEX бирж нь Монгол улсад Modulus-ийн системийн эх кодыг эзэмшиж, биржийн үйл ажиллагаа эрхлэн явуулах онцгой эрхтэй “exclusive” гэрээг байгуулаад байна. “Modulus” нь 2019 онд секундэд 10 сая гүйлгээг 40 нано секундийн хоцрогдолтой хурдтай хийх биржийн шийдлээрээ олон улсын “Benzinga Global Fintech Awards”-ын шагналыг хүртсэн. Modulus нь биржийн платформ, эрсдэлийн менежмент,

алгоритм, мэдээллийн аюулгүй байдлын хяналтын систем болон бусад биржийн шийдлүүдийг NASDAQ, Bank of America Corp (NYSE: BAC), JPMorgan Chase & Co (NYSE: JPM), Barclays PLC (NYSE: BCS), CMEG болон Chicago Merchantile exchange group гэх мэт дэлхийн санхүүгийн нэр хүнд бүхий байгууллагуудад нийлүүлдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий байгууллага юм.



ДАВУУ ТАЛУУД

- **Хамгийн өндөр үзүүлэлт.** 1 секундэд 84 сая гүйлгээг дэмжих хүчин чадалтай;
- **Боловсронгүй хяналтын систем.** Олон улсад патентлагдсан мөнгө угаалтын эсрэг болон Зах зээлийг урвуулан ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Anti Money Laundering (AML), Anti Market Manipulation (AMM) хяналтын шийдлүүдийг агуулсан.
- **Өндөр нууцлал, системийн аюулгүй үйл ажиллагаа.** “SQL injections” болон “DDos” төрлийн халдлагуудаас бүрэн хамгаалагдсан. Бирж нь хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, хадгалах олон улсын “General Data Protection Regulation (GDPR) болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ил тод үйл ажиллагааг хянах Европын холбооны “Markets in Financial Instruments Directive (MiFID) II” комплайнсүүдийн шаардлагууд, стандартуудыг тус тус бүрэн хангасан.



● Хууль ёсны харилцагч & хөрөнгө оруулагчийг таних олон улсын стандартыг хангасан “**Know your customer (KYC)**” хяналтын шийдэлтэй.

● **Ашиглахад хялбар.** Хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох шийдвэрт нь дэмжлэг үзүүлэх техник шинжилгээний бүхий л хэрэгслүүд багтсан. Хэрэглэгчийг санхүүгийн эрсдлээс сэргийлэх stop limit order, stop market, a trailing stop гэх мэт функцуудтэй.



БИРЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Capex хөрөнгийн бирж нь Crypto, Forex, Securities, Commodities буюу дижитал хөрөнгийн биржийн бүхий л үйлчилгээг нэг дороос авах боломжийг хэрэглэгчдэдээ олгож байгаа Монгол дахь хамгийн анхны төвлөрсөн, дижитал хөрөнгийн бирж юм. Энэ нь та өөрийн мөнгөн хөрөнгийг зөвхөн нэг төрлийн хөрөнгө оруулалтад хийж урт хугацаанд түгжих эсвэл

өөр төрлийн хөрөнгө оруулалт хийхдээ платформоо сольж орлого, зарлагын шимтгэл төлөх шаардлагагүй гэсэн үг юм.

Мөн хөрөнгө оруулалтуудынхаа багцын өгөөж, өсөлт, бууралтыг нэг дороос харьцуулсан байдлаар харж дараагийн шийдвэр гаргалтаа ашиглах давуу талыг танд олгох болно.

CRYPTO

- Олон улсад хамгийн их эрэлт, нийлүүлэлт бүхий топ койнууд болон дотоодын хүлээн зөвшөөрөгдсөн бусад койнуудад хөрөнгө оруулалт хийх, арилжаалах боломж;
- Шинэ төрлийн крипто валютыг зах зээлд танилцуулах, нэвтрүүлэх IEO босгох
- CAPEX биржийн үндсэн койныг эзэмшигч нарт нийт крипто валютын гүйлгээний шимтгэлийн орлогын 80 хувийг 7 хоног бүр урамшуулал болгон олгоно.

FOREX SECURITIES COMMODITIES

- Хөдөө, аж ахуйн салбарын бүхий л бүтээгдэхүүн, түүхий эд материалуудын борлуулалт нийлүүлэлтийг хамгийн түргэн шуурхайгаар, бодит цагийн үнэлэмжтэйгээр, 3 дагч талын оролцоогүйгээр шууд худалдаалагдах боломж.
- Биет бус метал, түүхий эдээр баталгаажсан буюу дотоодын уул уурхай, газрын тосны компаниудын бүтээгдэхүүнийг Дэлхийн жишиг үнэлгээгээр олон улсын зах зээлд шууд худалдаалах боломжийг бий болгосон бирж.



БИРЖИЙН ХӨГЖИЛ - ROADMAP

2021.IV УЛИРАЛ

- Биржийн нээлт
- Биржийн үндсэн койн IEO (CPX)

2022.II УЛИРАЛ

- Бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Андеррайтер компани байгуулах
- Крипто зээл, хадгаламжийн үйлчилгээ

2022.IV УЛИРАЛ

- Chicago Merchant Exchange хамтран ажиллах

2022.I УЛИРАЛ


- Аппликейшн хувилбар IOS, Android
- Forex
- Securities
- Commodities

2022.III УЛИРАЛ

- Private wealth management

CAPEX ОЛОН УЛСЫН ТӨВЛӨРСӨН БИРЖ

CAPEX биржийн онцлог давуу тал нь төвлөрсөн буюу хэрэглэгчдэд крипто биржээс гадна нэг дороос олон улсын валютийн арилжаа FOREX, үнэт цаас, түүхий эд болон олон улсын металлын биржид арилжаа, хөрөнгө оруулалт хийх боломжийг олгоно.



FOREX	Crypto	Metals	Indices	Energy	Equities	ETFs
All	Majors	Minors	Exotic			
Symbol	Vol (Bid)	Bid	Spread	Ask	Vol (Ask)	
> EUR/USD Euro/US Dollar	10 816 327	↓ 1.15917	0.00002	1.15919 ↓	8 278 826	

Хөрөнгө оруулалтын алтан дүрэм бол “Бүх өндгөө нэг сагсанд бус” хөрөнгөө тараан байршуулах буюу нэг төрлийн бус олон төрлийн хөрөнгөд мөнгөө байршуулж эрсдэлээ бууруулах байдаг. CAPEX биржийн систем нь энэхүү цогц үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлэх бүрэн боломжтой буюу олон улсад туршигдсан систем гэдгээрээ онцлог.



БҮХ БИРЖҮҮД ОРСОН, ОЛОН УЛСЫН БИРЖҮҮДТЭЙ ХОЛБОГДОХ

ТА САНХҮҮГИЙН АЛТАН
ДҮРМИЙГ БАРИМТЛАН
ӨНДӨГНҮҮДЭЭ
ОЛОН САГСАНД
ХУВААРИЛЖ ХИЙМЭЭР
БАЙНА УУ?

Монгол улсад криптовалют, блокчэйн технологи эрчимтэй хөгжиж, Үндэсний криптовалют болон крипто биржүүд сүүлийн үед ар араасаа цувран гарч байна. Хэрэглэгчдийн хөрөнгө оруулах ойлголт, эрэлт хэрэгцээ улам өсөж, зөвхөн криптовалютаас гадна олон улсын томоохон индекс, хувьцаа, үнэт метал зэрэг олон төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол байна. Тиймээс бид Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор CAPEX төвлөрсөн хөрөнгө оруулалтын биржийг танд хүргэхээр зорин ажиллаж байна.



Нийт койны ширхэг: 200'000'000'000

Нэгж үнэ: 0.25 мөнгө

Олон нийтэд санал болгох: 70% буюу 140 тэрбум ширхэг

- 2021.11.09-20 тэрбум ширхэг CPX койн /ICO анхдагч зах зээлд CPX-ийн нэгжийн үнийг 0.25 төгрөгөөр санал болгоно/
- 2021.11.24-20 тэрбум ширхэг CPX койн /ICO хоёрдогч зах зээлд CPX-ийн нэгжийн үнийг 0.50 төгрөгөөр санал болгоно/
- 2022 оны I улиралд 50 тэрбум ширхэг койныг олон нийтэд санал болгоно /Бусад арилжааны төрлүүд нэвтрэх үед жнь: FOREX/
- 2022 оны II улиралд 50 тэрбум ширхэг койныг олон нийтэд санал болгоно /Хэрэглэгчийн бааз суурь хамгийн өндөр болох үед/



Компанийн эрсдэлийн санд 30% буюу 60 тэрбум ширхэг үлдэнэ

Анхдагч зах зээлээс босгох мөнгөн дүн: 35,000,000,000 төгрөг (нийт койны 70%)

5 тэрбум төгрөг нь урьдчилсан захиалга 1 сар түгжих нөхцөлтэй (+5% бонус эрсдэлийн сангаас гаргана)

30 тэрбум нь IEO

Үнэ цэн: Биржийн гүйлгээнүүдийн шимтгэлийн орлогоос хэрэглэгчдэд урамшуулал хуваарилна

Крипто валют 80%

Forex, Securities, Commodities 30 хүртэлх хувь

IEO-с босгосон мөнгөний зориулалт:

28 тэрбум төгрөг биржийн үндсэн хөгжүүлэлт, сайжруулалт, боломжуудыг нэмэгдүүлэх

7 тэрбум төгрөг компанийн үйл ажиллагааны зардал

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Дэлхийн хөрөнгийн зах зээлийн бүх төрлийн стандарт, боломж, аюулгүй найдвартай байдал зэргийг бүрэн хангасан дижитал хөрөнгийн биржийг Монголд нэвтрүүлснээр, шинэ үеийн залуусын боловсрол, амьдралын хэв маяг, орчин нөхцөлийг сайжруулах бүхий л боломжийг тэгш хангах, цаашлаад эрүүл чийрэг, аз жаргалтай дунд давхрагын иргэдийн тоог өсгөх юм.

Энэхүү концепцтэй ижил утгаар бид компанийнхаа нийгмийн хариуцлагыг хамтын үнэ цэн бүтээх замаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Та CAPEX биржийн хэрэглэгч болсноор хөрөнгийн зах зээлийн талаарх анхан шатны ойлголтоос эхлээд мэргэжлийн түвшин хүртэлх бүх төрлийн сургалт, зөвлөгөөг үнэ төлбөргүй авах юм. Мөн өөрийн хөрөнгийг тогтмол өсөн нэмэгдүүлэх боломжтой мэргэжлийн арилжаачид, зөвлөхүүдтэй хамтран ажиллах боломжийг бид танд олгох болно.

“ДатаЛанд Технологи” ХХК-нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн тухай хууль, Иргэний хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж дүрэм журмыг мөрдлөг болгон олон улсын стандартын шаардлагыг хангасан CAPEX.mn дижитал хөрөнгийн биржийг Монгол улсад нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа билээ. Энэхүү танилцуулга нь Capex.mn дижитал хөрөнгийн биржийн үндсэн үйл ажиллагаа болон давуу тал, онцлог, ач холбогдол, байгууллагын зорилго зорилтыг та бүхэнд танилцуулж мэдээлэл өгөх зорилготой бөгөөд биржид арилжаалагдах койныг худалдан авах, зарах талаарх зөвлөмж биш юм.

Танилцуулгад дурдах зарим мэдээлэл нь гадны эх сурвалжийн олон төрлийн мэдээллийн урсгалаас авсан бөгөөд тухайн мэдээллүүдийн үнэн зөв, бүрэн бүтэн байдалд манай байгууллага хариуцлага хүлээхгүй.

Та дижитал хөрөнгийн биржийн арилжаанд оролцохдоо Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд болон Төв банкнаас гаргаж холбогдох мэдэгдэл, зөвлөмжид тулгуурлан эцсийн шийдвэрээ зөвхөн өөрөө гаргах шаардлагатай. Энэхүү танилцуулгад агуулагдаж буй мэдээллүүд биржийн арилжаа болон койнттой холбоотой арилжаа, гэрээ хэлцэл, хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөхгүй болно.

Бидний нэвтрүүлэхээр ажиллаж буй sarex.mn дижитал хөрөнгийн бирж нь олон улсын стандартын шаардлагын дагуу алдагдлыг хязгаарлах STOP LOSS функцыг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү функц нь хэрэглэгч таныг эрсдэлээс хамгаалах хэдий ч бирж дээр арилжаатай холбоотой бүх эрсдэлийг та өөрөө бүрэн хариуцах шаардлагатай.

“Дата ланд” ХХК-нь Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг тул энэхүү танилцуулгад агуулсан мэдээлэл нь хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлт, холбогдох төрийн

байгууллагын шийдвэрүүдийн дагуу өөрчлөгдөх боломжтой бөгөөд ирээдүйд гарч болох бодит үр дүн тооцоолол, төсөөлөл нь өөрчлөгдөхгүй гэсэн баталгаа өгөхгүй юм.

Бид танд дижитал хөрөнгийн бирж дээр арилжаа хийхэд ямарваа нэгэн зөвлөгөө өгөхгүй бөгөөд та хөрөнгө оруулах, арилжаанд оролцохоосоо өмнө холбогдох санхүү, татвар, хуулийн мэргэжлийн байгууллагуудаас шаардлагатай зөвлөгөө мэдээллийг авч эрсдэлээс өөрийгөө урьдчилан сэргийлнэ үү.



CAPITAL EXCHANGE OF MONGOLIA

THANK YOU

WWW.CAPEX.MN